



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1370
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН
П.БУЯНДЭЛГЭР ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн Пүрэвдоржийн Буяндэлгэрийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Пүрэвдоржийн Буяндэлгэрийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн


Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Пүрэвдоржийн Буяндэлгэрийн сонгуулийн мөрийн хөтөлбөр / 3 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн сонгуулийн хороонд

Хавсралт: 3 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ПҮРЭВДОРЖИЙН БУЯНДЭЛГЭРИЙН

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

1.5 сая гаруй оршин суугчтай нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн үзэл баримтлалыг шинээр тодорхойлж, эрүүл, аюулгүй, амьдралын таатай орчин бүрдүүлсэн, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоонд тулгуурласан сайн засаглал бүхий “ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ-ЭРҮҮЛ ХОТ” болгон хөгжүүлнэ.

Хоёр. Зорилт

1. Иргэд, оршин суугчдадаа үйлчилдэг, тэднийг дэмждэг, хамтран ажилладаг, хүнд сурталгүй ХОТ;

2. Иргэд, оршин суугчид нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, амрах, зугаалах, тоглох, алхах, ажил, хөдөлмөр эрхлэх таатай орчныг бүрдүүлсэн ХОТ;

3. Гэр хорооллын бүсэд амьдарч байгаа 800 гаруй мянган иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах шаардлагад нийцсэн төсвийн шударга хуваарилалт, зарцуулалтын бодлого бүхий ХОТ.

Гурав. Арга хэмжээ

1. Нийслэл Улаанбаатар хотыг хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлсэн, өрсөлдөх чадвартай, бие даан хөгжиж, өөрөө өөрийгөө тэтгэх боломжтой болгох эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, нийслэлийн бүх нөөц, бололцоо, төр, захиргааны байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг энэхүү зорилтыг хангахад чиглүүлнэ.

2. Хот байгуулалт, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрийг ханган хөгжлийн тогтвортой орчин бүрдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сайн засаглалыг хөгжүүлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулна.

3. Дэлхийн томоохон хотуудын хөгжлийн загварыг нутагшуулж, үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын үйлчилгээг олон улсын жишигт хүргэнэ.

4. Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын чиг үүргийн давхардлыг арилгаж, төвлөрлийг сааруулах, оновчтой бүтэц, зохион байгуулалтын дагуу төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, хотыг бүсчлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн төвд байршиж байгаа төр, захиргааны байгууллагууд /яамдууд болон Засгийн газрын агентлагууд, нийслэлийн төр,

захиргааны байгууллагууд, зарим дүүргийн Засаг даргын Тамгын газар гэх мэт/-ыг үе шаттайгаар дагуул хот, дэд төвүүд рүү байршуулах ажлыг эхлүүлнэ.

5. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын засаглалыг сайжруулж, үр ашиггүй, алдагдалтай ажиллаж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, менежментэд нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч нарыг татан оролцуулах бодлого баримталж, алдагдлыг бууруулах, үр ашигтай ажиллуулах арга хэмжээ авна. Зарим нийслэлийн өмчит компаниудыг нээлттэй хувьцаат компани болгож, хувьцааг нь Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжаалах ажлыг эхлүүлнэ.

6. Мэдлэгт суурилсан, өндөр технологийн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор залуу бизнес эрхлэгчид, стартап/гарааны компаниудыг дэмжих тусгай сан байгуулж, санхүүжилтийн асуудлыг гадаад улс, олон улсын байгууллагын тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэнэ.

7. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөх, нийслэлийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа олон нийтийн санал, оролцоонд тулгуурлан ил тод байх, оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэх зарчмыг мөрдөж ажиллана. Энэ нь нийслэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулан хариуцлагатай болгох, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хот байгуулалт, барилга байгууламж барих ажлыг хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулахад чухал ач холбогдолтой болно.

8. Нийслэлийн иргэд, оршин суугч нь амьдарч буй орчноо тохижуулсан, мод, бут тарьсан, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсан бол дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.


9. Нийслэл, дүүрэг, хороог эдийн засаг, нийгмийн цогцолбор, засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, сум, багтай адилтган шийдвэр гаргаж ирсэн практикийг өөрчилж, нийслэлийн удирдлагыг бэхжүүлэх ажлыг манлайлан идэвх, санаачилга гаргаж ажиллана.

10. Нийслэлийн хэт төвлөрлийг сааруулж, олон төвт, суурьшлын оновчтой тогтолцоонд суурилсан хот байгуулах, дэд төв, дагуул хотуудыг хөгжүүлэх үйл ажиллагааг төрөөс татварын бодлогоор зохицуулах талаар санаачилга гаргаж ажиллана.

11. Гэр хорооллыг барилгажуулах, орон сууцжуулах хөтөлбөрийг дан ганц улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр бус, нийслэлээс урт хугацаатай үнэт цаас гаргах замаар санхүүжүүлэх ажлыг судалж, зохион байгуулна.

12. Агаарын бохирдлын улмаас амьсгалын замын, зүрх судасны, төв мэдрэлийн системийн өвчлөл, харшлын өвчнүүд, удамшлын эмгэг, хавдар зэрэг өвчнүүдийн тархалт ихсэж, хүүхэд, залуучуудын эрүүл мэндэл ноцтой аюул учруулж байгаа тул цаашид айл өрх бүрийг агаар шүүгчтэй болгох аян өрнүүлнэ.

13. Улаанбаатар хот дотор усны хоолой, борооны ус зайлуулах ил болон далд шугам хоолойгүй авто зам барих явдлыг эцэс болгоно.



14. Жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа оршин суугчдад Хорооноос хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах үүднээс Хорооны санхүүг бэхжүүлж, үйл ажиллагаа тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

15. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл, боломжийг сайжруулах, хүнд суртлыг багасгах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт зарим төрлийн төрийн үйлчилгээг хялбаршуулсан журмаар олгох ажлыг эхлүүлнэ. Ингэснээр бизнес эрхлэх эрх зүйн орчин боловсронгуй болж, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх боломж нэмэгдэнэ.

16. Хүүхэд, залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гэр хороололд жил бүр 20-иос доошгүй тоглоомын талбай байгуулна.

17. Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг гэр хорооллын бүсэд байгуулна.

18. Иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор “Гэрэлтэй хот” аяныг хэрэгжүүлж, гудамж, зам, талбайг бүрэн гэрэлтүүлнэ.

19. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал гарах нөхцөлийг бүрдүүлсэн, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэхгүй, нийслэлийн нутаг дэвсгэрт үйлчилж байгаа бүх эрх зүйн акт (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагаас баталсан журам, дүрэм, зааврууд)-ыг хянаж, хүчингүй болгох ажлыг зохион байгуулна.

20. Гэр хорооллын бүсэд ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, Жижиг, дунд үйлдвэр, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Хороо бүрд тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

21. Нийслэлийн удирдлагыг жил бүрийн I улиралд иргэд, олон нийтэд ажлаа тайлагнадаг болгоно. Ингэснээр иргэд нийслэлийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцах боломж нэмэгдэж, нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал хангагдана.

